

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
2023 оны 11 сарын 16 өдрийн
916. албан бичгийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ
11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хийгдэх ажил	Хүрэх үр дүн	Хугацаа	Биелэлт
1	Хугацаатай мэдээ, тайлан гаргах	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг	дараа сарын 02-ны дотор	Тайлант хугацаанд манай байгууллагад 201,360.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 184,818.1 мянган төгрөгийг зарцуулж 16,541.9 мянган төгрөг хэмнэсэн.
		Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах	Дараа сарын 08-ны дотор	Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан.
		Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх	Дараа сарын 05-ны дотор	10-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан.
2	Санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Хяналт шалгалтын үр дүн	11 сар	Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бус 9 байгууллагад нийт 23 байгууллагад хийж 4.168.320,6 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 12.016,8 мянган төгрөгийг улсын төсвийн орлого болгуулахаар, 28.060,8 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7.100,2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар нийт 47.177,8 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоосон. Үр дүн: Актын барагдуулалт 58 хувь.
3	Баянтал сумын орон нутаг хөгжлийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Баянтал сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023.09 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 707,867.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 999.5 мянган төгрөгийн хугацаатай 2 албан шаардлага 706,867.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн. Албан шаардлагын биелэлт гаргах хугацаа болоогүй.

4	Аймгийн ЗДТГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн ЗДТГазрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 449,073.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 13,169.6 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт, 435,904.2 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлэв. Акт барагдуулах хугацаа болоогүй.
5	Шивээговь сумын орон нутаг хөгжлийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023.08 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 90 хувьтай үргэлжилж байна.
6	Шивээговь сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Шивээговь сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 90 хувьтай үргэлжилж байна.
7	Баянтал сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Баянтал сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 40 хувьтай үргэлжилж байна.
8	Сүмбэр сумын Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд санхүүгийн шалгалт хийх	Сангийн үйл ажиллагаа сайжирна	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын хоршоо хөгжүүлэх сангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 10 хувьтай үргэлжилж байна.
9	Сум дундын ойн ангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх	Санхүүгийн сахилга бат сайжирна.	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сум дундын ойн ангийн 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалт 20 хувьтай үргэлжилж байна.

10	Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах	Хамтын ажиллагаа сайжирна.	11 сар	Аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран А.Ундармаа болон Ц.Соёлмаа нарын цалин хөлс дээр Мэргэшсэн нягтлан бодогч Э.Цэлмэгбаярыг шинжээчээр ажиллуулсан.
11	Сүмбэр сумын лаборатори 5 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын лаборатори 5 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдэж байна. Шалгалтын явц 90 хувьтай байна.
12	Илчлэг шивээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын лаборатори 5 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн. Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн 10 асуудал буюу 90% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн бөгөөд шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд 18 заалт бүхий хугацаатай зөвлөмж өгөв. Зөвлөмжийн хариу ирүүлэх хугацаа болоогүй.
13	Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна	11 сар	Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн. Шалгалтаар тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны түвшиний 32 хувь нь 2-р түвшин буюу ДАВТАМЖТАЙ, үнэлэгдсэн ба дотоод аудитаар илэрсэн 7 асуудлаас 5 нь нөлөө ихтэй буюу "Сайжруулах шаардлагатай" дүгнэлтийг өгөв. Иймд илэрсэн дутагдлыг арилгуулах 19 заалт бүхий хугацаатай зөвлөмжийг хүргүүлэв. Зөвлөмжийн хариу ирүүлэх хугацаа болоогүй.
14	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах	11 сар	Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны

				мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 10 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдалд хяналт шалгалт хийсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 97,9 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 4.9 хувиар өсчээ.
15	Мэдээллийн ил тод байдлыг хангах	Мэдээллийн ил тод байдал хангагдах	11 сар	Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 25 мэдээ мэдээллийг байршуулсан. Байгууллагын facebook хуудсаар 24 мэдээллийг иргэд олон нийтэд түгээж ажиллалаа.
16	Бусад ажил	Байгууллагын үйл ажиллагаа сайжирна.	11 сар	Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 5 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. 11 дүгээр сарын 02-ны өдөр "Эрсдэлд суурилсан дотоод аудит хийх нь", "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай" сэдвүүдээр аймгийн төвийн байгууллагуудад сургалт зохион байгуулсан. 11 дүгээр сарын 10-ны өдөр "АЗ"-ын мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагч хамрагдсан. 11 дүгээр сарын 15-ны өдөр ХШҮ-ний хэлтсээс байгууллагын жилийн эцсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. 11 дүгээр сарын 16-ны өдөр ТАСЗ-с байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. 11 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд Сангийн яамнаас зохион байгуулсан Төрийн байгууллагын дотоод аудитор, улсын байцаагчдыг чадавхижуулах сургалтад байгууллагын бүх албан хаагч хамрагдсан.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дарга:



Н.Алтанцэцэг